



**БАКАЛАВРЫН ЗЭРЭГ ОЛГОХ ҮНДСЭН ХӨТӨЛБӨРТ
2019-2020 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД
ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 СЭЗИС-д оюутан элсүүлэхэд Дээд боловсролын тухай хуулийн холбогдох заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/79 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, СЭЗИС-ийн элсэлтийн нэгдсэн бодлого болон энэхүү журмыг баримтална.
- 1.2 2019–2020 оны хичээлийн жилд энэхүү журмын 4-т заасан мэргэжил, хөтөлбөрөөр оюутан элсүүлнэ.
- 1.3 СЭЗИС-ийн Ректорын тушаалаар томилогдсон Элсэлтийн комисс нь “Элсэлтийн комиссын ажиллах журам”-ийг мөрдлөг болгон элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, элсэхийг хүсэгчдийг бүртгэх, СЭЗИС-ийн удирдах зөвлөлөөс баталсан хяналтын тоонд багтаан шалгаруулалт явуулах, ирсэн санал, гомдлыг барагдуулах зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэнэ.
- 1.4 Элсэлттэй холбоотой (элсэлтийн журам, гадаад иргэнийг суралцуулах журам, бүртгүүлэх заавар, хугацаа, шалгаруулах тов, мэргэжлийн танилцуулга гэх мэт) мэдээллийг admission.ufe.edu.mn хуудсанд байршуулна.

ХОЁР. ЭЛСЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1 СЭЗИС-д элсэхийг хүсэгч нь Боловсролын үнэлгээний төвийн хүчинтэй батламжтай байна. 2017-2019 онуудад ЭЕШ өгсөн бол аль илүү оноогоор нь бүртгүүлнэ.
- 2.2 “Монгол хэл, бичгийн шалгалт”-ын босго оноог хангасан байна.
- 2.3 Энэ журмын 4.1-т заасан мэргэжил, хөтөлбөр, бүлэгт хамаарах хичээлүүдээр ЭЕШ өгч, босго онооны шаардлага хангасан байна.
- 2.4 Элсэхийг хүсэгч нь өөрийн суралцах бэлтгэл (сурлага), авъяас чадвар, туршлага, хувийн зан чанар, хэрхэн суралцахаа илэрхийлсэн эсээ бичиж элсэлтийн комисст цахим хэлбэрээр 2019/06/25 өдрийн 18:00 цагаас өмнө цахимаар илгээсэн байна. Эсээ элсэгчийн өөрийн бүтээл байна.
- 2.5 Дараах тохиолдолд ЭЕШ-гүй элсүүлэн суралцуулж болно. Үүнд:
 - 2.5.1 Дээд боловсролтой иргэн хоёр дах дээд боловсрол эзэмших;
 - 2.5.2 Дипломын боловсролтой иргэн мэргэжлийнхээ дагуу бакалаврын хөтөлбөрт элсэх;
 - 2.5.3 Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн, улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын оноог Боловсролын Үнэлгээний Төвөөр дүйцүүлэн тооцуулж, дүйцүүлсэн батламж авч бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэх;
- 2.6 Гадаад иргэнийг СЭЗИС-ийн “Гадаадын иргэнийг суралцуулах журам”-ын дагуу элсүүлнэ.

ГУРАВ. БҮРТГЭЛ

- 3.1 СЭЗИС-ийн элсэлтийн бүртгэл орон даяар цахим хэлбэрээр 2019/06/21-ий өдрийн 09:00 цагаас 2019/06/25-ы өдрийн 18:00 цаг хүртэл admission.ufe.edu.mn хаягаар бүртгэнэ.
- 3.2 Элсэлтийн бүртгэлийн хураамжийг 1 удаа төлөх ба 20'000 төгрөг байна.
- 3.3 СЭЗИС-ийн үйл ажиллагаанаас үл хамааран бүртгэлээ цуцлах тохиолдолд бүртгэлийн хураамжийг буцааж олгохгүй.

ДӨРӨВ. ШАЛГАРУУЛАЛТ

4.1 Мэргэжил бүрд харгалзах шалгуур, бүлгийг дараах хүснэгтэд тайлбарын хамт тусгав.

Хөтөлбөр	Мэргэжил	Бүлэг	Тайлбар
Шаталсан хөтөлбөр	Нягтлан бодох бүртгэл	Бүлэг V	Чадамжид суурилсан шаталсан сургалттай виртуал хөтөлбөр (СЭЗИС-д 4 жил суралцах ухаалаг цахим хөтөлбөр)
	Санхүү		
	Банк		
	Бизнесийн удирдлага		
	Мэдээллийн систем		
Үндсэн хөтөлбөр	Нягтлан бодох бүртгэл	Бүлэг I	СЭЗИС-д 4 жил суралцах хөтөлбөр
	Санхүү		
	Банк		
	Бизнесийн удирдлага		
	Маркетинг		
	Мэдээллийн систем		
	Эдийн засаг	Бүлэг II	
	Эрх зүй	Бүлэг III	
	Аялал жуулчлал	Бүлэг IV	
Зочлох үйлчилгээ	Бүлэг V		
Олон улсын үндсэн хөтөлбөр	Нягтлан бодох бүртгэл /2+2 жил/	Бүлэг I	- БНХАУ-ын Дунбейн Санхүү эдийн засгийн их сургуультай хамтарсан хөтөлбөр /хятад хэл суурьтай/ - Тайваны Ази их сургуультай хамтарсан хөтөлбөр /англи хэл суурьтай/
	Санхүү /2+2 жил/		- БНХАУ-ын Дунбейн Санхүү эдийн засгийн их сургуультай хамтарсан хөтөлбөр /англи хэл суурьтай/ - Тайваны Ази их сургуультай хамтарсан хөтөлбөр /англи хэл суурьтай/
	Бизнесийн удирдлага /2+2 жил/		- БНХАУ-ын Дунбейн Санхүү эдийн засгийн их сургуультай хамтарсан хөтөлбөр /англи хэл суурьтай/ - БНХАУ-ын Далианы их сургуультай хамтарсан хөтөлбөр /хятад хэл суурьтай/ - БНСУ-ын Вүүсонг их сургуулийн Солбридж бизнесийн сургуультай хамтарсан хөтөлбөр /англи хэл суурьтай/ - БНСУ-ын Хандонг Глобаль их сургууль тай хамтарсан хөтөлбөр /англи хэл суурьтай/ - Бусад улсад шилжин суралцах англи хэл дээр суралцах хөтөлбөр
	Эдийн засаг /2+2 жил/		- БНХАУ-ын Далианы Политехникийн их сургуультай хамтарсан олон улсын эдийн засаг худалдааны хөтөлбөр /хятад хэл суурьтай/
	Эрх зүй /2+2 жил/		Бүлэг III
	Зочлох үйлчилгээ /1+2+1 жил/	Бүлэг V	СЭЗИС-д 1 жил + БНХАУ-ын Шандуны аялал жуулчлалын коллежид 2 жил + СЭЗИС-д 1 жил суралцах хөтөлбөр
	Аялал жуулчлал /1+2+1 жил/	Бүлэг IV	СЭЗИС-д 1 жил суралцах хөтөлбөр

4.2 Мэргэжил бүрийн босго оноог бүртгүүлэх бүлгээр харуулав.

Бүлэг I	Математик ба англи хэлний хичээлийн ЭЕШ-ын дундаж оноо 620;
Бүлэг II	Математикийн хичээлийн ЭЕШ-ын оноо 650, англи хэлний хичээлийн ЭЕШ-ын оноо 620;
Бүлэг III	Математик ба нийгмийн тухай мэдлэг хичээлийн ЭЕШ-ын дундаж оноо 620;
Бүлэг IV	Математик ба англи хэлний хичээлийн ЭЕШ-ын дундаж оноо 560;
Бүлэг V	Математик ба англи хэлний хичээлийн ЭЕШ-ын дундаж оноо 500;

- 4.3 Тэнцсэн элсэгчийн жагсаалтыг бүртгэл хаасны дараа аймаг, хот харгалзахгүй бүлэг тус бүрээр гаргаж, admission.ufe.edu.mn хаягаар урьдчилан зарлана.
- 4.4 Элсэлтийн комисс хяналтын тоонд багтсан элсэгчидтэй холбоо тогтоож, асуудлыг дор бүр нь нягталж, өөрчлөлт гарсан тохиолдолд дараагийн хүнд хяналтын тоонд багтсан тухай мэдээллийг хүргэнэ.
- 4.5 Жагсаалтын дагуу, заасан хугацаанд мэргэжил, хөтөлбөрийн сонголт хийлгэх ба элсэгч цагтаа байгаагүйн хариуцлагыг элсэлтийн комисс хүлээхгүй.

ТАВ. ХӨНГӨЛӨЛТИЙН НӨХЦӨЛ

- 5.1 ЭЕШ-ийн үндэсний хэмжээний босго оноог хангасан элсэхийг хүсэгчийг дараах нөхцөлд 4.1-р заалтад хамааруулахгүйгээр шууд элсүүлж болно.
- 5.1.1 Улсын математикийн олимпиадад медальт болон тусгай байр эзэлсэн бол сонирхсон мэргэжлээр нь;
- 5.1.2 Улсын мэдээлэл зүйн олимпиадад амжилттай оролцсон, аймаг болон дүүргийн мэдээлэл зүйн олимпиадад шагналт байрт шалгарсан бол “Мэдээллийн систем” мэргэжлээр;
- 5.1.3 Улсын нийгмийн тухай мэдлэгийн олимпиадад 1-5-р байр эзэлсэн бол өдрийн үндсэн хөтөлбөрийн “Эрх зүй”-н мэргэжлээр;
- 5.1.4 Улсын хятад хэлний олимпиадад медальт болон тусгай байр эзэлсэн, хятад хэлний төвшин тогтоох HSK шалгалтын 5 болон түүнээс дээш төвшингийн оноотой бол дараах мэргэжлээр элсүүлнэ. Үүнд:
- ЭЕШ-ын математикийн оноо 620-с дээш, нийгмийн тухай мэдлэгийн оноо 480-с дээш бол БНХАУ-тай хамтарсан “Эрх зүй” мэргэжлээр;
 - ЭЕШ-ын математикийн оноо 620-с дээш, англи хэлний оноо 480-с дээш бол БНХАУ-тай хамтарсан “Олон улсын худалдаа, эдийн засаг” мэргэжлээр;
- 5.1.5 “Математик, статистик загварчлал”-ын улсын уралдаан”-ы эхний 3 байр эзэлсэн багийн гишүүн (ЭЕШ-ийн үндэсний хэмжээний босго оноог хангасан) бол I, II, IV, V-р бүлгийн мэргэжлээс сонгож;
- 5.1.6 СЭЗИС-ийн нэрэмжит “Математик ба Англи хэлний олимпиад”-ын нийлбэр дүнгээр эхний 15 хүртэлх байрт шалгарсан бол I, II, IV, V бүлгийн мэргэжлээс сонгож;
- 5.1.7 СЭЗИС-ийн нэрэмжит “Математик ба Нийгмийн тухай мэдлэгийн олимпиад”-ын нийлбэр дүнгээр эхний 15 хүртэлх байрт шалгарсан бол “Эрх зүй” мэргэжлээр;
- 5.1.8 СЭЗИС-ийн нэрэмжит “Мэдээлэл зүйн олимпиад”-д эхний 15 хүртэлх байрт шалгарсан бол “Мэдээллийн систем” мэргэжлээр;
- 5.1.9 СЭЗИС-ийн нэрэмжит “Маркетингийн олимпиад”-д эхний 10 хүртэлх байрт шалгарсан бол “Маркетинг” мэргэжлээр;
- 5.2 СЭЗИС-тай хамтарсан, гүнзгийрүүлсэн сургалттай ангийн төгсөгчид хамтын ажиллагааны гэрээ болзлуудыг хангасан, мөн “Өөрийн гоо сорих ухаалаг цахим хөтөлбөр”-т идэвхтэй хамрагдсан бол элсэлтийн комиссын шийдвэрээр сонирхсон мэргэжлээр нь элсүүлнэ.

- 5.3 СЭЗИС-ийн “Өөрийгөө сорих ухаалаг цахим хөтөлбөр”-т хамрагдсан идэвх, эсээ бичилтийн шалгуур хангасан байдал, элсэгчийн урлаг, спортын амжилт, нийгэм, хүмүүнлэгийн үйлсэд оруулсан хувь нэмрийг элсэлтийн комисс үнэлэх ба элсэгчийн бичгээр гаргасан хүсэлт, нотлох баримтыг үндэслэн элсүүлж болно.

ЗУРГАА. СУРАЛЦАХ ЭРХИЙН БИЧИГ ОЛГОХ

- 6.1 СЭЗИС-ийн цахим бүртгэлийн системд бүртгэгдсэн иргэнд онооны жагсаалтын дагуу “Суралцах эрхийн бичиг” олгож, хөтөлбөр мэргэжлийг баталгаажуулна.
- 6.2 Суралцах эрхийн бичиг”-ийг Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт 2019/06/26-ы өдрөөс 28-ы өдрүүдэд хуваарийн дагуу олгоно.
- 6.3 Суралцах эрхийн бичиг”-ийг олгоход дараах материалыг бүрэн бүрдүүлсэн байна. Үүнд:
- 6.3.1 Иргэний үнэмлэх, хуулбарын хамт (Насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ, хуулбарын хамт)
 - 6.3.2 Бүрэн дунд боловсролын гэрчилгээ (Гадаадад ЕБС төгссөн бол боловсролын бичиг баримтыг БСШУСЯамаар баталгаажуулсан байна.)
 - 6.3.3 Сурагчийн хувийн хэрэг
 - 6.3.4 Төгссөн сургуулийн дэлгэрэнгүй тодорхойлолт
 - 6.3.5 ЭЕШ-ын батламж
 - 6.3.6 Сүүлийн 6 сард авахуулсан 3x4 хэмжээтэй цээж зураг 2 хувь
 - 6.3.7 Сургалтын төлбөрийн урьдчилгаа 500,000₮ тушаасан баримт, хуулбарын хамт
- 6.4 Орон нутгаас элсэгч нь сургалтын төлбөрийн урьдчилгааг тушаасан бол “Суралцах эрхийн бичиг”-ийг admission.ufe.edu.mn хуудсанд байрлах зааврын дагуу хэвлэж авчирна.

ДОЛОО. ШИНЭ ЭЛСЭГЧИЙН БҮРТГЭЛ

- 7.1 “Суралцах эрхийн бичиг”-тэй элсэгч 2019/08/19-21-ий өдрүүдэд бүртгэлээ баталгаажуулж, суралцах гэрээ байгуулна. 2019/08/22-ы өдрөөс эхлэн чиглүүлэх хичээлд хуваарийн дагуу хамрагдана.
- 7.2 Элсэгчид бүртгүүлэхдээ өөрийн биеэр дараах материалуудыг авчирна. Үүнд:
- 7.2.1 Суралцах эрхийн бичиг
 - 7.2.2 Иргэний үнэмлэх
 - 7.2.3 Сургалтын төлбөрийн зөрүү төлсөн баримт, хуулбарын хамт (зөрүүг суралцах эрх олгох үед мэдэгдэнэ)
 - 7.2.4 СЭЗИС-ийн системд байрлуулсан “Бакалаврын өдрийн хөтөлбөрт суралцах гэрээ”-тэй сайтар танилцаж, системээс хэвлэх ба гарын үсгээр баталгаажуулж авчирна.
- 7.3 Заасан хугацаанд бүртгүүлээгүй элсэгчийн хуваарийг хүчингүйд тооцно.

НАЙМ. СЭЗИС-ИЙН СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТ

- 8.1 2019 оны ЭЕШ-ийн оноо нь элсэх бүлгийн хичээл тус бүрээр 800 бол 2019-2020 оны хичээлийн жилийн 16 кредитийн төлбөрөөс чөлөөлнө.
- 8.2 2019 оны ЭЕШ-ийн элсэх бүлгийн хичээлийн дундаж оноо 750-с дээш бол 2019-2020 оны хичээлийн жилийн 8 кредитийн төлбөрөөс чөлөөлнө.

ХОЛБОО БАРИХ УТАС:

- Олон улсын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн мэргэшсэн сургууль– 457701
- Бакалаврын сургалтын алба– 451956, 70158818, 70158806, 70008087
- Чадамжид суурилсан виртуал сургалттай хөтөлбөр – 70008083

ЭЛСЭЛТИЙН ЦАХИМ ХУУДАС:

admission.ufe.edu.mn

www.facebook.com/ufeinfo

БАНК, ДАНСНЫ МЭДЭЭЛГЭЛ:

Сургалтын төлбөрийн урьдчилгааг хийх:

Дансны дугаар: УБхотын банк - 2612007984

Хас банк - 5000010393

Хаан банк – 5129032930

Хүлээн авагчийн нэр: Санхүү эдийн засгийн их сургууль

Гүйлгээний утга: Элсэгчийн овог, нэр, регистрийн дугаар